



Гүйцэтгэлийн аудитын тайлан

Баянтээг ХК-ийн 2019 онд хэрэглэгчдийг дулаанаар хангахад нүүрсийг тасралтгүй хангасан ч үйл ажиллагааны төлөвлөлт хангалтгүй байна.

2020 оны 11 дугаар сар

АУДИТЫН СЭДЭВ: БАЯНТЭЭГ ХК-ЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	4
Хүснэгтийн товьёг	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	6
БҮЛЭГ 1. Удирдлагын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байна.	8
А.1 Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хуулийн дагуу оновчтой хэрэгжүүлсэн байна.	8
А.1.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааг хуулийн дагуу явуулсан байна.	8
А.1.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэрэгжүүлсэн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн байна.	10
А.2 Аудитын хороог байгуулан ажиллаагүй байна.	11
А.2.1 Аудитын хороо нь хууль, компанийн дүрэмд заасан эрх үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.	11
А.2.2 Аудитын хороо байгуулагдаагүйгээс үүргээ гүйцэтгээгүй байна. .	11
Б. Уулын ажлын төлөвлөлт үндэслэлгүй, авлага барагдуулах ажил хийгдээгүй, удирдлагын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.	11
Б.1 Уулын ажлын төлөвлөлт үндэслэлгүй, биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй, харин дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийсэн байна.	11
Б.1.1 ТЭЗҮ-д нийцүүлэн уулын ажлын төлөвлөгөөг төлөвлөөгүй, зүсэлтийн дундаж талбайн тооцоолол алдаатай байна.	11
Б.1.2 Биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй, харин дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийсэн байна.	15
Б.2 Уурхайн нүүрсний олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ч авлага барагдуулах талаар хангалтгүй байна.	15
Б.2.1 Нүүрсний олборлолт төлөвлөсөн хэмжээндээ хэрэгжиж байна.	15
Б.2.2 Нүүрсний борлуулалтын төлөвлөгөөг 50.4 хувиар давуулан биелүүлсэн нь төлөвлөлт үндэслэлгүй байна.	16
Б.2.3 Борлуулалтын орлогын төлөвлөгөөг 35.5 хувиар давуулсан боловч борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.	16
Б.2.4 Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.	17
Б.3 Удирдлагын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй, зарим зардлуудад хяналт хангалтгүй байна.	20
Б.3.1 Удирдлагын үйл ажиллагааны зардлын төлөвлөлт үндэслэлгүй, зарим зарцуулалтын хяналт хангалтгүй байна.	20

Б.3.2 Түлш шатахууны зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.	23
Б.3.3 Сэлбэг хэрэгслийн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан ч, тайлагналт хангалтгүй байна.	23
В. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.	24
В.1 Хөрөнгийн худалдан авалтыг хуулийн дагуу үр ашигтай хэрэгжүүлэн ажилласан байна.	24
В.1.1 Эд хөрөнгийн худалдан авалт үр дүнтэй болсон байна.	24
В.1.2 Үндсэн хөрөнгийг худалдан авах ажиллагаа хуулийн дагуу явагдсан байна.	25
В.2 Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр дүнтэй боловч эд хөрөнгийн тооллогын үр дүн хангалтгүй байна.	26
В.2.1 Эд хөрөнгийн тооллого, тооцоог хуулийн дагуу хийгдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.	26
В.2.2 Машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн явагдаж байна.	26
Холбогдох байгууллагын санал:	27
Саналд өгсөн тайлбар:	30
ДҮГНЭЛТ: 32	
ЗӨВЛӨМЖ:	33
ХАВСРАЛТУУД:	35

Товчилсон үгийн тайлбар

ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
МУЗГ	Монгол улсын засгийн газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮЭ	Үйлдвэрчний эвлэл
ШУТИС	Шинжлэх ухаан техникийн их сургууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
АМГТГ	Ашигт малтмал газрын тосны газар
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	ТУЗ-ийн хурлын шийдвэрүүд	8
Хүснэгт 2	Нүүрс үйлдвэрлэлийн нөөц	12
Хүснэгт 3	Олборлох нүүрсний хэмжээ (алдаатай тооцоолол)	12
Хүснэгт 4	Олборлох нүүрсний хэмжээ (бодит тооцоолол)	13
Хүснэгт 5	Хөрс хуулалтын хайгуулын шугам	14
Хүснэгт 6	Хөрс хуулалт, нүүрс олборлолтын тооцоо /хайгуулын шугамаар/	14
Хүснэгт 7	Нүүрс олборлолтын тооцоо	15
Хүснэгт 8	Нүүрс борлуулалт	16
Хүснэгт 9	Орлогын дансны мэдээлэл	17
Хүснэгт 10	Авлагын задаргаа	17-18
Хүснэгт 11	5 жилийн авлагын судалгаа	18
Хүснэгт 12	Ногдол ашгийн хуваарилалт	20
Хүснэгт 13	2020 оны нийгмийн өмнөх хариуцлагын хүрээний ажлууд	21
Хүснэгт 14	Хэтрүүлэн зарцуулсан зардлууд	22
Хүснэгт 15	Шатах тослох материал, түлш шатахууны зардлын задаргаа	23
Хүснэгт 16	Сэлбэгийн зардлын техникийн ашиглалт	24
Хүснэгт 17	Хөрөнгө оруулалтын төлөвлөлт	25

Зургийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Зураг 1	Хөрс хуулалтын төлөвлөгөө	13
Зураг 2	Нүүрс олборлолтын төлөвлөгөө	15
Зураг 3	Мал хүлээн авсан акт	19
Зураг 4	Мал буцаан хүлээлгэн өгсөн акт	19

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Нүүрс борлуулалт (аймгуудаар)	16

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт 1	Нийгмийн өмнөх хариуцлагын задаргаа /аймаг, сум орон нутгийн нэрийг алдаршуулж байгаа тамирчдад дэмжлэг үзүүлэх/	21
Хавсралт 2	2019 оны кассын зарцуулалт	22

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/53 дугаар тушаалыг үндэслэн Баянтээг ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнд аудитыг хийж гүйцэтгэв.

Аудитын зорилт

Баянтээг ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнг шалган дүгнэлт, зөвлөмж боловсруулан холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах үндсэн асуудлаар аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Төлөөлөн удирдах зөвлөл, аудитын хорооны үйл ажиллагаа үр дүнтэй, үр нөлөөтэй хэрэгжиж байгаа эсэх
- Уурхайн үндсэн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байгаа эсэх
- Өмч хөрөнгийн татан авалт, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг үр дүнтэй хэрэгжүүлж байгаа эсэх

Аудитын хамарсан хүрээ

Энэхүү аудитыг Баянтээг ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүнг ирүүлсэн ажлын тайлан, мэдээ судалгаа, бодит байдал болон холбогдох бусад материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын хязгаарлалт

.....

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ: Төрийн хяналт, шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3001), гүйцэтгэлийн аудитын журмыг ашиглан Баянтээг ХК-ийн удирдлага, ТУЗ болон бусад ажилтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа авах, тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн байдлыг бодит байдалтай харьцуулах, мэдээ, судалгаа, ажлын тайланд дүн шинжилгээ хийх зэрэг арга зүйг баримталсан бөгөөд аудитын хөтөлбөр болон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулах ажиллагаа хийгдэв.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг дарга, тэргүүлэх аудитор Л.Ламаачин удирдан, аудитын менежер Д.Гансүх үе шатны хяналтыг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн аудитын багийн аудитор С.Шийлэгмаа, П.Норпил, Э.Энхбаяр нар хийж гүйцэтгэлээ.

Аудитыг 2020 оны 11 дүгээр сарын 05-аас 12 дугаар сарын 04-ны дотор гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

.....

БҮЛЭГ 1. Удирдлагын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байна.

А.1 Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хуулийн дагуу оновчтой хэрэгжүүлсэн байна.

А.1.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааг хуулийн дагуу явуулсан байна.

Баянтээг ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 04 тоот тогтоолоор төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг дараах байдлаар баталжээ. Үүнд:

1. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдээр: О.Батжаргал, Ю.Батсайхан, Г.Баясгалан, И.Доржсүрэн, Д.Миеэгомбо, Д.Нэмэхбаяр, Д.Энхбат нарын 7 гишүүн

2. “Баянтээг” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдээр: Г.Батсүх, З.Дашзэвгэ, Р.Өлзийжаргал, Л.Энхбат нарын 4 гишүүн ажилласан байна.

Компанийн дүрмийн 7.2-т заасны дагуу ТУЗ нь 11 гишүүнтэй байх бөгөөд үүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат гишүүн байхаар заажээ.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2019 онд нийт 6 удаа хуралдаж 14 тогтоол баталж ажилласан байна.

ТУЗ-ийн хурлын шийдвэр:

Хүснэгт 1

Хуралдсан он, сар, өдөр	Хурлын тогтоолын дугаар	Хурлаас гарсан шийдвэр	Шийдвэрийн товч утга
2019.02.11	01	Компанийн 2018 оны үйл ажиллагааны дүнгийн тухай	Баянтээг ХК-ийн 2018 оны үйл ажиллагааг хангалттай гэж дүгнэсэн
2019.02.11	02	2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлах тухай	2019 оны санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөөг 1 дүгээр, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсан
2019.02.11	03	Гүйцэтгэх удирдлагын тайланг батлах тухай	Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны тайланг хангалттай гэж дүгнэсэн
2019.02.11	04	Ногдол ашиг хуваарилах тухай	2018 онд 2,018.5 сая төгрөгийн ашигтай ажиллаж нийт 1,000.0 сая төгрөгийн ногдол ашиг хуваарилсан
2019.02.11	05	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хэлэлцэх асуудлын жагсаалтыг баталсан
2019.02.11	06	Ажлын хэсэг байгуулах тухай	Шахмал түлш үйлдвэрлэх боломжийг судлах ажлын хэсгийг 1 дүгээр, техник тоног төхөөрөмж судлах ажлын хэсгийг 2 дугаар хавсралтаар баталсан

2019.02.11	07	Урамшуулал олгох тухай	Гүйцэтгэх захирлын гэрээний биелэлтийг үндэслэн мөнгөн урамшуулал олгосон
2019.04.01	08	Хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай	Өмнөх хурлын хэлэлцэх асуудлыг хэвээр үлдээн хурлыг дахин зарласан
2019.04.01	09	2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай	Хайгуулын өрмийн машин 200.0 сая төгрөгөөр худалдан авах гэснийг хайгуулын өрөм тавих зардал болгон өөрчилсөн
2019.04.24	10	Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга сонгох тухай	Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар О.Батжаргалыг томилсон
2019.04.24	11	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай	Ээлжит бус хурлын товыг зарлан хэлэлцэх асуудлыг жагсаалтыг баталсан
2019.05.16	12	“Өв Эко Мийт” ХХК-тай байгуулсан зээлийн гэрээг дуусгавар болгох тухай	Аймгийн Засаг даргын хүсэлтээр “Өв Эко Мийт” ХХК-ний эргэлтийн хөрөнгөд зориулж “Баянтээг” ХК-тай байгуулсан гэрээний хэрэгжилтийг дуусгавар болгож орон нутагт ногдох ногдол ашгаас үе шаттайгаар тооцож барагдуулах шийдвэр гаргасан
2019.05.20	13	Санхүүжилт шийдвэрлэх тухай	БОАЖЯ-ны “Агаарын бохирдол бууруулах сан”-аас ирсэн 400.0 сая төгрөгийг шахмал түлшний үйлдвэрт зориулж санхүүжүүлэх шийдвэр гаргасан
2019.06.03	14	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал удирдах дарга томилох тухай	2019.06.04-ний өдрийн хурлыг удирдах даргаар Аймгийн ИТХурлын дарга А.Ишдоржийг томилсон

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, хурлыг хуульд заасны дагуу, шаардлагатай үед нэмэлт хуралдааныг зохион байгуулж ажиллажээ.

Компанийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу тодорхой асуудал эрхэлсэн аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодын гишүүнийг ТУЗ-ын дарга томилж, чөлөөлөх үүрэгтэй байна.

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх 3 хороог 2019 онд байгуулаагүй байна.

Аудитын явцад Баянтээг ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 08 тоот тогтоолоор ТУЗ-ийн гишүүдийг шинээр томилжээ. Шинээр томилогдсон ТУЗ нь 2020 онд Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлд заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх гурван хороодыг байгуулан ажиллаж байна.

А.1.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэрэгжүүлсэн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн байна.

Компанийн тухай хуулийн 76 дүгээр зүйлийн 76.1.11 дэх хэсэгт заасны дагуу Баянтээг ХК-ийн ТУЗ-ийн 2020 оны 04 дүгээр сарын 03-ний өдрийн 01 тогтоолоор 2019 оны үйл ажиллагааг хангалттай хэмээн дүгнэж, 2020 оны санхүү, үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталжээ.

ТУЗ-ийн 2019 оны 5 дугаар сарын хуралдаанаар шахмал түлшний үйлдвэр, түүний явцын талаар хэлэлцэн “Бүтээлч – Өвөрхангай-2020” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам “Агаарын бохирдлыг бууруулах сан”-аас батлагдан ирсэн 400.0 сая төгрөгийг Баянтээг ХК-ийн хөрөнгөөр байгуулж байгаа шахмал түлшний үйлдвэрт зориулан санхүүжүүлэхээр болжээ. 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу шахмал түлшний үйлдвэр байгуулах ажлыг 1,400.0 сая төгрөгийн өртгөөр гүйцэтгэсэн байна.

Үйлдвэрийн барилга, шаардлагатай тоног төхөөрөмжөөр тоноглон ашиглалтад оруулж, 2020 онд нийт 200 тонн шахмал түлшийг Өвөрхангай аймгийн төвийн хэрэглэгчдэд нийлүүлж туршилтын байдлаар ашиглуулах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Аудитын явцад үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцахад 100 тонн шахмал түлшийг үйлдвэрлэсэн байна.

Баянтээг ХК-ийн хувьд шахмал түлш үйлдвэрлэлийн гол түүхий эд болох барьцалдуулагч цавууг уурхайн үйлдвэрлэлийн явцад бий болсон нунтаг нүүрс, хөрсний шар шороо, улаан буудай зэргийг ашиглан бэлтгэж байна. ТУЗ-ын 2020 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 16 тоот тогтоолоор шахмал түлшний барьцалдуулагч цавуу үйлдвэрлэх техник, тоног төхөөрөмжийг худалдан авах, суурилуулах ажлын зардалд 300.0 сая төгрөг зарцуулах эрхийг гүйцэтгэх захиралд өгчээ. Гүйцэтгэх захирлын зүгээс тоног төхөөрөмжийн асуудлыг бүрэн шийдэж, компанийн хэрэгцээг бүрэн хангаж байгаа, бусад аж ахуй нэгжид нийлүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байгаа талаар онцлон ярьж байна.

А.1.3 Гүйцэтгэх удирдлагын зүгээс хэрэгжүүлсэн үйл ажиллагаа оновчтой байна.

Компанийн гүйцэтгэх удирдлага нь Компани тухай хууль, компанийн дүрэм болон ҮЭ-тэй байгуулсан хамтын гэрээ, Хөдөлмөрийн дотоод журмын дагуу өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулжээ.

Компанийн эрх бүхий албан тушаалтнууд компанийн дүрэм, ТУЗ-ийн баталсан дотоод журамд заасан үүргийг биелүүлэн ажилласан байна.

Ажилчдын нийгмийн асуудал, хөдөлмөр хамгааллын талаар ҮЭ-тэй байгуулсан гэрээ, хөдөлмөрийн дотоод журамд тодорхой зүйл заалтууд тусгаж, хэрэгжүүлэх арга хэмжээ авч ирсэн байна.

Хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлд заасны дагуу 2019 онд нийт ажилтнуудыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах ажилд зориулан 2.6 сая төгрөгийг зарцуулсан. Мөн ҮЭ-тэй байгуулсан гэрээний 3 дугаар зүйлд заасны дагуу нийт ажилчдын цалин хөлсийг 29.0 хувиар нэмэгдүүлэн ажилласан байна.

Хуваарийн дагуу ажилласан ажилчдыг амралтад амраах, үр дүнгийн урамшууллыг хагас болон бүтэн жилээр тооцож олгожээ. Үндсэн болон нэмэгдэл цалинд 830.9 сая төгрөг, үр дүнгийн урамшуулалд 65.4 сая төгрөгийг зарцуулсан байна.

Гүйцэтгэх удирдлагын 2018, 2019 оны үйл ажиллагааны тайланг үндэслэн ТУЗ-тэй байгуулсан үр дүнгийн гэрээний хэрэгжилтийг хангалттай хэмээн дүгнэж гүйцэтгэх захиралд 2019 онд 23.0 сая төгрөг, 2020 онд 25.4 сая төгрөгийн урамшуулал олгосон байна.

Компанийн үндсэн үйл ажиллагаатай уялдуулан техникүүдийн их засвар, сэлбэгийн хангалт, шинээр бий болгох хөрөнгө оруулалтын ажлуудыг оновчтой төлөвлөн шаардлагатай

засвар үйлчилгээг хийж гүйцэтгэн шинээр 4 техникийг худалдан авчээ. 3 нэр төрлийн 4 ширхэг техникийг 2.733,5 сая төгрөгөөр худалдаж авч ашигласнаар хөрс хуулалт, нүүрсний олборлолт, борлуулалтын төлөвлөгөөг давуулан биелүүлж нүүрс нийлүүлэлтийг захиалагч талд чирэгдэлгүйгээр нийлүүлэн ажилласан байна.

А.2 Аудитын хороог байгуулан ажиллаагүй байна.

А.2.1 Аудитын хороо нь хууль, компанийн дүрэмд заасан эрх үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Компанийн санхүүгийн үйл ажиллагааг олон улсын стандарт болон хуулийн дагуу явуулж байгаа эсэхэд хяналт тавих голлох үүргийг хэрэгжүүлэгч аудитын хороог 2019 онд байгуулан ажиллаагүй байна.

Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу аудитын хороо нь дараах чиг үүрэгтэй юм. Үүнд:

- ❖ Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийг олон улсын стандартад нийцүүлэн, дотоод хяналтын болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, санхүү эдийн засгийн бусад мэдээллийн үнэн бодит байдалд хяналт тавих,
- ❖ Дотоод хяналтын албаны удирдлага, ажилтныг томилох, цалин урамшууллыг тогтоох санал боловсруулах,
- ❖ Аудитын байгууллагыг сонгох, түүний ажлын хөлсний хэмжээг тогтоох талаар санал боловсруулах,
- ❖ Их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлд хяналт тавих, дүгнэлт гаргах,
- ❖ Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад асуудал

Компани нь дотоод хяналтын ажилтантай боловч компанийн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт тавих чиглэлээр хийгдсэн ажил байхгүй байна.

А.2.2 Аудитын хороо байгуулагдаагүйгээс үүргээ гүйцэтгээгүй байна.

Аудитын хороо байгуулагдаагүй учир хорооны дүгнэлт, ажил сайжруулах төлөвлөгөө хийгдээгүй байна.

Б. Уулын ажлын төлөвлөлт үндэслэлгүй, авлага барагдуулах ажил хийгдээгүй, удирдлагын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Б.1 Уулын ажлын төлөвлөлт үндэслэлгүй, биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй, харин дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийсэн байна.

Б.1.1 ТЭЗҮ-д нийцүүлэн уулын ажлын төлөвлөгөөг төлөвлөөгүй, зүсэлтийн дундаж талбайн тооцоолол алдаатай байна.

Баянтээг ХК нь 2013 онд ШУТИС-н Уул уурхайн хүрээлэнгийн боловсруулсан “Баянтээгийн нүүрсний ордыг ашиглах ил уурхайн Техник эдийн засгийн үндэслэл”, 2019 онд “Баянтээгийн нүүрсний ордыг ил аргаар ашиглах Техник эдийн засгийн үндэслэл”-ийг “ДАТА РЕСУРС” ХХК боловсруулсан байна.

Маркшейдерийн зураглалын ажлын тайлан, 2013 онд боловсруулсан ТЭЗҮ, урьд оны үйл ажиллагааны тайлан зэрэг баримт бичгүүдийг үндэслэн жил бүрийн уулын ажлын төлөвлөгөөг боловсруулан АМГТГ-ын Нүүрсний судалгааны хэлтсээр хянаж, батлуулан мөрдөж иржээ.

Баянтээгийн нүүрсний ордыг ил уурхайн тээвэртэй ашиглалтын системээр жилийн турш ашиглах ба 2019 онд уулын ажил нь хөлс хуулалт, нүүрс олборлолт, нөхөн сэргээлт, ус таталт гэсэн 4 хэсгээс бүрдсэн байна. Уулын ажлын хүрээнд 2012, 2013 онуудад шинээр бий болсон уурхайн үндсэн гол амыг сэргээн хөрс хуулалт, нүүрс олборлолтыг уурхайн үндсэн техник болох ЭКГ-5А экскаватор, DOOSAN 300LCV, HYUNDAI-2900, HYUNDAI 520LC-9S

экскаваторууд, TEREX 3305E 2ш, NORTH BENZ 4ш, HOWO-60 2ш авто самосвалууд, СББ-2М өрмийн машин 1ш, JD-1400E өрмийн машин 1ш, D65E бульдозер 1ш, LG-930 дугуйт ачигч, SD-300 дугуйт ачигч-1ш зэрэг техникийн хослолоор гүйцэтгэхээр төлөвлөгөөнд тусгагдсан байна. Тухайн онд техникийн хүчин чадлыг нэмэгдүүлэх зорилгоор HYUDAI 850LC-9 экскаватор 1ш, CAMC HM390 авто самосвал 2ш, LIUGONG 4180 авто грейдэр 1ш зэрэг нийт 4 ширхэг техникийг худалдан авч ажилласан байна.

Уулын ажлын төлөвлөгөөнд 400.0 мян/м³ хөрс хуулж 140.0 мян/тн нүүрс олборлож үүнээс нүүрсний хаягдлыг 5.4%, олборлолтын үеийн бохирдлыг 0.55%-с ихгүй байхаар тооцоолж 133.21 мян/тн нүүрсийг борлуулахаар тусгагджээ. Гүйцэтгэлээр 600.3 мян/м³ хөрс хуулж, 238.54 мян/тн нүүрс олборлон, 27.97 мян/тн нүүрсний хаягдал тооцож 210.6 мян/тн нүүрс борлуулсан байна. Гэтэл 2013 онд боловсруулсан “Баянтээгийн нүүрсний ордыг ашиглах ил уурхайн Техник эдийн засгийн үндэслэл”-д тусгагдсан байдлыг харахад 2019 онд 655.05 мян/м³ хөрс хуулж, 297.75 мян/тн нүүрс олборлон, нүүрсний хаягдал 3.2 хувь, нийт 293.11 мян/тн нүүрс борлуулахаар тусгагдсан байна. 2019 оны уулын ажлын төлөвлөгөө нь ТЭЗҮ-д тусгагдсанаас зөрүүтэй байна.

Нүүрсний үйлдвэрлэлийн нөөц

Хүснэгт 2

№	Уулын ажлын нэр	Хэмжих нэгж	Техник, эдийн засгийн үндэслэл	2019 оны уулын ажлын төлөвлөгөө	2019 оны уулын ажлын гүйцэтгэл	Нөөцийн хөдөлгөөн		
						1962 он	1/1/2019	1/1/2020
						Анх батлагдсан нөөц /мян.тн/	Үлдэгдэл нөөц /мян.тн/	Үлдэгдэл нөөц /мян.тн/
1	Хөрс хуулалт	мян/м ³	655.05	400.0	600.3	29687.6	25649.25	25410.71
2	Нүүрс олборлолт	мян/тн	297.75	140.0	238.54			
3	Нүүрсний хаягдал	мян/тн	9.52	7.56	27.94			
4	Нүүрсний бохирдол	мян/тн	4.88	0.77	0			
5	Нүүрс борлуулалт	мян/тн	293.11	133.21	210.60			
6	Борлуулалтын орлого	сая/төг	5799.0	3863.1	6108.4			

Компанийн 2019 онд гүйцэтгэх уулын ажлын хэмжээг тооцоолсныг шалгахад хайгуулын шугамд хийх зүсэлтийн талбайнууд нь дундаж талбайтайгаа уялдахгүй байна. Маркшейдерийн тооцоолсноор:

Хүснэгт 3

Олборлох нүүрсний хэмжээ / алдаатай тооцоолол/						
Хайгуулын шугам	Зүсэлтийн талбай, м2		Дундаж талбай, м2	Зүсэлт хоорондын зай, м	Эзлэхүүн жин, тн/м3	Нүүрсний хэмжээ, тн
35-36	62	50	87	94	1.3	10631.4
36-37	50	58.3	79.15	105	1.3	10804
37-38	58.3	50	83.3	97	1.3	10504.1
42-43	84	82	125	62.7	1.3	10188.8
43-44	82	0	82	21	1.3	2238.6
49-50	91	89	135.5	104	1.3	18319.6
50-51	89	201	189.5	106	1.3	26113.1
51-52	201	0	201	22	1.3	5748.6
53-54	570	414	777	45	1.3	45454.5
Нийт						140002.7

Аудитын явцад олборлох нүүрсний хэмжээг тооцоолж үзэхэд: Жишээ нь

- ✓ 35 дугаар хайгуулын шугамын зүсэлтийн талбай 62м²,
- ✓ 36 дугаар хайгуулын шугамын зүсэлтийн талбай 50м² байхад дундаж талбай 56м² байна.


Нийт олборлох нүүрсний хэмжээг олох = дундаж талбай * зүсэлт хоорондын зай * эзлэхүүн жин = 56 * 94 * 1.3=6843.2 тн байна тооцооллыг дараах хүснэгтээс харахад:

Хүснэгт 4

Олборлох нүүрсний хэмжээ / бодит тооцоолол/						
Хайгуулын шугам	Зүсэлтийн талбай, м2		Дундаж талбай, м2	Зүсэлт хоорондын зай, м	Эзлэхүүн жин, тн/м3	Нүүрсний хэмжээ, тн
35-36	62	50	56	94	1.3	6843.2
36-37	50	58.3	54.15	105	1.3	7391.475
37-38	58.3	50	54.15	97	1.3	6828.315
42-43	84	82	83	62.7	1.3	6765.33
43-44	82	0	82	21	1.3	2238.6
49-50	91	89	90	104	1.3	12168
50-51	89	201	145	106	1.3	19981
51-52	201	0	201	22	1.3	5748.6
53-54	570	414	492	45	1.3	28782
Нийт						96746.52

Маркшейдерийн тооцооллыг аудитын явцад хийсэн тооцооллоос 43,256.2 тн нүүрсээр илүү тооцоолсон алдаагаа хүлээн зөвшөөрсөн. Хөрс хуулалт, нүүрс олборлолтын тооцоог сараар хийж календарчилсан төлөвлөгөөг боловсруулсан байна. Үүнд оны эхний 4 сард хөрс хуулалтыг төлөвлөөгүй, харин 5-9 сар хүртэл хөрс хуулалт хийж нүүрс олборлолтыг жилийн турш хийхээр тусгасан байна.

Зураг 1



2019 онд хийгдэх хөрс хуулалтыг хайгуулын шугамаар нь харьцуулбал:

Хүснэгт 5

Техник эдийн засгийн үндэслэл	2019 оны уулын ажлын төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл
ХШ 44-45	ХШ 34-35	ХШ 52-54
ХШ 45-46	ХШ 35-36	ХШ 43-38
ХШ 46-47	ХШ 36-37	
ХШ 47-48	ХШ 37-38	
ХШ 48-49	ХШ 53-54	
ХШ 51-52	ХШ 54-55	
ХШ 52-53		
ХШ 53-54		
ХШ 54-55		
ХШ 55-56		

Хүснэгтээс харахад ТЭЗҮ-д хайгуулын 10 шугамд хөрс хуулахаар төлөвлөжээ. Гэтэл уулын ажлын төлөвлөгөөнд ТЭЗҮ-д тусгагдсан хайгуулын 2 шугамыг төлөвлөсөн байгаа нь харилцан уялдаатай байдлыг алдагдуулж байна. Үүнээс гадна ТЭЗҮ-д тусгагдаагүй хайгуулын 34-38 шугамыг үндэслэлгүйгээр уулын ажлын төлөвлөгөөнд тусгажээ. Мөн уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй хайгуулын 43-38 шугамд хөрс хуулалт хийсэн. Энэ нь ТЭЗҮ-д нийцүүлэн уулын ажлын төлөвлөгөөг төлөвлөөгүй, төлөвлөгөөний дагуу хөрс хуулалтыг гүйцэтгээгүй байна.

Хөрс хуулалт, нүүрс олборлолтын төлөвлөгөөг хайгуулын шугамаар нь харахад:

Хүснэгт 6

Он	Хайгуулын шугам	Давуулан биелүүлсэн хувь	Олборлолтын шугам	Давуулан биелүүлсэн хувь
2018	ХШ 51-54	36.5	ХШ 40-43	28.8
2019	ХШ 52-54 ХШ 43-38	50.1	ХШ 53	50.5
2020	ХШ 47-51 ХШ 40-36	37.7	ХШ 36-43 ХШ 53-50	Хүлээгдэж байгаа
Нийт		124.3		79.3

Хүснэгтээс харахад: 2018 оны ХШ 51-54 шугам, 2019 онд ХШ 52-54 шугамуудад хийсэн байгаа нь хөрс хуулалтыг дээрх шугамуудад давхардуулан хийсэн байна. Дээрх 3 онд хөрс хуулалтыг 553,2 мян м³ буюу 124.3 хувиар давуулж биелүүлсэн боловч нүүрс олборлолтыг хуулсан талбайгаас хийгээгүй байна. Энэ нь хөрс хуулалтын үр дүнд бий болсон олборлох бэлэн нүүрсний нөөцийг жилээс жилд нэмэгдүүлж байна. Иймд хөрс хуулалтын хэмжээг ирэх онд зохих хэмжээгээр бууруулан дагаж гарах зардлыг хэмнэх боломжтой байна.

Баянтээг ХК нь 2020 онд уулын ажлаар 597.5 мян/м³ хөрс хуулж, 200.0 мян/тн нүүрс олборлож үүнээс нүүрсний хаягдлыг 3.2%, 196.8 мян/тн нүүрсийг борлуулахаар төлөвлөн, хайгуулын 47-51, 40-36 дугаар шугамын хооронд хөрс хуулалтыг, хайгуулын 36-43, 53-50 дугаар шугамын хооронд олборлолтыг явуулахаар ТУЗ -ийн хуралд оруулан хэлэлцүүлж батлуулсан байна.

Б.1.2 Биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй, харин дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийсэн байна.

Уулын ажлын 2019 оны төлөвлөгөөнд нөхөн сэргээлтийн /биологийн болон техникийн/ ажлын зардлыг 11.2 сая төгрөгөөр гүйцэтгэхээр тусгажээ. Уурхайн олборлолтоос шалтгаалсан нөлөөллийг бууруулах, үлдэгдэл нөлөөллийг дүйцүүлэн хамгаалах шаардлага үүсдэг байна. Уурхайд 2019 онд биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байна. Дүйцүүлэн хамгаалах ажилд 25.0 сая төгрөгийг төсөвлөн арга хэмжээг орон нутгийн удирдлагуудтай тохиролцож Баянтээг багийн төвд 2 га газарт “Ногоон төгөл” барьж байгуулжээ. Ногоон байгууламжийг барихад нийт 20.0 сая төгрөгийг зарцуулан ажилласан байна.


Б.2 Уурхайн нүүрсний олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ч авлага барагдуулах талаар хангалтгүй байна.

Б.2.1 Нүүрсний олборлолт төлөвлөсөн хэмжээндээ хэрэгжиж байна.

Баянтээг ХК-н 2013 онд боловсруулсан нүүрсний ордыг ашиглах ил уурхайн техник, эдийн засгийн үндэслэлд 2019 онд 297.75 мян/тн нүүрс олборлохоор тооцоолсон.

Гэтэл уулын ажлын төлөвлөгөө болон үйл ажиллагааны төлөвлөгөөнд 140.0 мян/тн нүүрс олборлохоор батлуулсан байгаа нь ТЭЗҮ-ээс 157.75 мян/тн нүүрсээр бага байна. Энэ нь аймгийн Засаг даргын 2013 оны 02 дугаар сарын 1/58 тоот бичигт “Өвөрхангай аймагт дулааны цахилгаан станц баригдахаар төлөвлөгдөж байгаа тул ТЭЗҮ-ийг 300-500 мян/тн нүүрс олборлох хэмжээнд боловсруулж” өгөхийг хүссэн хүсэлтийн дагуу тооцоолж ТЭЗҮ-д оруулсан байна. Дараах мэдээллээс нүүрс олборлолтын тооцоог харуулбал:

Зураг 2



Нүүрс олборлолтын тооцоо

Хүснэгт 7

№	Уулын ажлын нэр	Хэмжих нэгж	Техник, эдийн засгийн үндэслэл	2019 оны уулын ажлын төлөвлөгөө	2019 оны уулын ажлын гүйцэтгэл	Зөрүү	
						Уулын ажлын төлөвлөгөөний биелэлт /хувь/	Техник, эдийн засгийн үндэслэл /хувь/
1	Нүүрс олборлолт	мян/тн	297.75	140.0	238.54	170.4	80.1

Б.2.2 Нүүрсний борлуулалтын төлөвлөгөөг 50.4 хувиар давуулан биелүүлсэн нь төлөвлөлт үндэслэлгүй байна.

Тус компани нь 2019 онд 140.0 мян/тн нүүрс борлуулахаар төлөвлөж, 210.6 мян.тн нүүрс борлуулан ажиллаж борлуулалтын төлөвлөгөөг 50.4 хувиар буюу 70.6 мян/тн нүүрс борлуулж давуулан биелүүлсэн байна. Нүүрс борлуулалт дараах байдалтай байна. 1тн нүүрсний үнэ 29000 төгрөг /НӨАТ орсон/

Хүснэгт 8

	Аймгийн нэр	2019 оны төлөвлөгөө /мян.тн/	2019 оны гүйцэтгэл /мян.тн/
1	Өвөрхангай	62.0	78.9
2	Баянхонгор	20.0	33.5
3	Архангай	15.0	25.4
4	Булган	5.0	7.1
5	Улаанбаатар	12.5	24.7
6	Говь-Алтай	5.0	6.6
7	Дархан	5.0	4.8
8	Завхан	2.0	3.8
9	Төв	1.5	5.5
10	Сэлэнгэ	1.0	1.26
11	Хөвсгөл	1.0	3.57
12	Эрдэнэт	10.0	11.66
13	Дундговь		0.2
14	Налайх		3.5
15	Ховд		0.04
	Нийт дүн	140.0	210.53

Аймгуудыг график дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1



Тус компани нь 2020 онд 200.0 мян/тн нүүрс борлуулахаар төлөвлөсөн. 2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн байдлаар 164.6 мян/тн нүүрс борлуулсан байна.

Б.2.3 Борлуулалтын орлогын төлөвлөгөөг 35.5 хувиар давуулсан боловч борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Борлуулалтын орлогын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2019 оны 2 дугаар тогтоолоор нүүрсний борлуулалтын орлого 4350.0 сая төгрөг, дулаан үйлдвэрлэлийн орлого 21.5 сая төгрөг, бусад орлого 100.0 сая төгрөг, нийт 4471.5 сая төгрөгийн төлөвлөгөөг баталжээ. Гүйцэтгэлээр нүүрсний борлуулалтын орлого 5921.6 сая төгрөг, хүүгийн орлого 176.5 сая төгрөг, БОАЖЯ-

аас 400.0 сая төгрөг, бусад орлого 2.8 сая төгрөг нийт 6508.3 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Нүүрсний борлуулалт, дулаан үйлдвэрлэлийн орлогыг 4371.5 сая төгрөгөөр төлөвлөж, 5921.6 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 1550.1 сая төгрөгөөр буюу 35.5 хувиар давуулсан. Мөн Хүүгийн орлого буюу бусад орлогыг 100.0 сая төгрөгөөр төлөвлөж, 179.3 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 79.3 сая төгрөгөөр буюу 79.3 хувиар давуулжээ. Нийт 4471.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 6500.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2029.4 сая төгрөгөөр буюу 45.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Орлогын дансны мэдээлэл:

Хүснэгт 9

	Харилцагч банк	Данс	Нүүрсний борлуулалт	Хүүгийн орлого	бусад орлого	БОАЖЯам	Нийт орлого
1	ХААН банк	5558032623	2,741.3	48.9		400.0	3,190.2
2	ХААН банк	5540020333	44.0				44.0
3	Төрийн банк	190500012340	856.9	8.9	0.1		869.6
4	ХААН банк	5558001004	2,258.8		2.7		2,261.5
5	Төрийн банк	190500062899		75.5			75.5
6	ХААН банк	5558051487		43.2			43.2
7	Касс		20.6				24.3
Нийт орлого			5,921.6	176.5	2.8	400.0	6,500.9

Б.2.4 Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Баянтээг ХК нь 2019 оны эхэнд 714.2 сая төгрөгийн авлагатай, 2063.6 сая төгрөгийн өглөгтэй тайлагнагдсан бол оны эцэст 790.3 сая төгрөгийн авлагатай, 2164.1 сая төгрөгийн өглөгтэй гарсан байна. Авлага урьд оноос 10.6 хувиар буюу 76.1 сая төгрөгөөр өссөн харин өглөг 4.8 хувиар буюу 100.5 сая төгрөгөөр өссөн байна. Гэрээ байгуулсан байгууллагатай жилийн эцэст тооцоо нийлсэн актаар үлдэгдлийг баталгаажуулсан байна. Авлагын задаргааг тодруулбал: Нийт 47 ААН, 6 иргэний нийт 439.9 сая төгрөгийн авлагатай. Үүнээс:

Хүснэгт 10

д/д	Аймгийн нэр	Аж ахуйн нэр	Мөнгөн дүн
Өвөрхангай аймгийн нийт ААН-ээс			268.1
1	Үүнээс: Өндөр дүнтэй авлагатай ААН-үүд	Хангамж өргөө ХХК	16.9
2		Өвбаян-Улаан ХХК	44.0
3		Онги-илч ХХК	23.4
4		Хужирт-Илч ХХК	19.5
5		Газрын улаач ХХК	33.7
6		Дэлгэрэх хүнс ХХК	11.9
7		Сод ээл ХХК	11.6
8		Мөнхийн ундраа ХХК	15.7
9		Жигүүр оргил ХХК	12.6
10		Иргэн Амархүү	17.3
Баянхонгор аймгийн ААН-ээс			49.3
1	Үүнээс: Өндөр дүнтэй авлагатай ААН-үүд	Чандмань ХХК	12.8
2		Баян-Аараг ХХК	13.1
Улаанбаатар хот, болон бусад аймгуудаас			114.3
1		Бэрх оньс ХХК	13.7

2	Үүнээс: Өндөр дүнтэй авлагатай ААН-үүд	Пинган ХХК	70.8
3		Эрдэнэ хангай зам ХХК	18.3
4		Тэнүүн холдинг ХХК	6.8
Архангай аймгийн ААН-ээс		Эх голомтын илч ХХК	8.2
1	Бусад авлага	ӨВ Эко мийт ХХК-д зээлүүлсэн	220.0
2		Сэлбэг хэрэгсэлд	18.8
3		Байгаль орчны нөхөн сэргээлтийн зардал байршуулсан	35.6
4		Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ	9.9
5		Мал угаалгын ванн	10.0
6		Навтгар хайрхан ХХК	6.8
7		ӨВ. Татварын хэлтэс	47.7
8		ӨВ. Нийгмийн даатгалын хэлтэс	1.6

Баянтээг ХК нь 2020 оны эхэнд 790.3 сая төгрөгийн авлагатай, 2164.1 сая төгрөгийн өглөгтэй гарсан бол 2020 оны 3 дугаар улирлын байдлаар 1048.9 сая төгрөгийн авлагатай, 771.4 сая төгрөгийн өглөгтэй байна. Энэ хугацаанд 1392.7 сая төгрөгийн өглөгийн барагдуулсан байна. Гэрээ байгуулсан байгууллагатай 2, 3 дугаар улиралд тооцоо нийлсэн актыг үйлдэж үлдэгдлийг баталгаажуулаагүй байна.

Тайлант онд урьд онуудаас дамжиж ирсэн авлагыг барагдуулах тал дээр арга хэмжээ авч ажиллаагүй байна. Сүүлийн 5 жилийн судалгаагаар жил тутам авлага өссөн байна.

Хүснэгт 11

Он	2015	2016	2017	2018	2019
Авлага	193.4	111.1	602.1	711.4	790.3

Хүснэгтээс харахад: 2015-2016 онд 57.5 хувиар авлагыг бууруулсан бол 2016-2017 онд 541.9 хувь буюу 5.4 дахин өссөн байгаа нь ӨВ Эко мийт ОНӨХК-д 450.0 сая төгрөгийг зээлүүлсэнтэй холбоотой, 2017-2018 онд 18.1 хувь, 2018-2019 онд 11.1 хувиар өссөн байна.

Баянтээг ХК нь жил бүрийн 9 дүгээр сард хэрэглэгч ААН-тэй Нүүрсний гэрээг байгуулж ажилладаг ба 2019 онд 60 ААН, 8 иргэнтэй, 2020 онд 57 ААН, 5 иргэнтэй гэрээ байгуулжээ. Нүүрс нийлүүлэх гэрээний 3 дугаар заалтын Хэрэглэгч байгууллагын хүлээх үүрэгт 3.2-т “Хэрэглэгч нь улирал бүр хангагч байгууллагатай тооцоо нийлж, сар бүр төлбөр тооцоог бүрэн барагдуулж байх” мөн 5 дугаар заалтын Хариуцлага 5.3-т “Хэрэглэгч байгууллагын хүсэлтийг харгалзан зээлээр олгосон нүүрсний үнийг тогтоосон хугацаанд төлөөгүй нөхцөлд хоногийн 0.5%-ийн алданги тооцно”, 6 дугаар заалтын Гэрээ цуцлах 6.4-т “Тухайн оны эцэст өглөгтэй гарсан тохиолдолд гэрээг цуцална” гэж гэрээнд тусгаж нийлүүлэгч болон хэрэглэгч талууд нь хүлээн зөвшөөрч гарын үсэг зуржээ.

Гэтэл тус компани гэрээний дагуу хугацаандаа төлбөрөө барагдуулаагүй ААН-д хоногийн 0.5 хувийн алданги тооцож ажиллаагүй, оны эцэст өглөгтэй гарсан байгууллагын гэрээг цуцалж ажиллаагүй зэрэг гэрээний үүргээ биелүүлж ажиллаагүйгээс оны эцэст авлага өндөр дүнтэй гарсан байна.

Тус компани нь Өвбаян-Улаан ХХК-аас 2020 оны 11 сарын байдлаар 84.3 сая төгрөгийн авлагатай. Баянтээг ХК-ийн гүйцэтгэх захиралд дээрх компани албан бичгээр бус аман хэлэлцээгээр өрийг мөнгөн хэлбэрээр барагдуулах боломжгүй болсон тухай мэдэгджээ. Компанийн гүйцэтгэх захирал ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлээгүй, өр барагдуулах гэрээ байгуулалгүй 291 толгой малыг 51.2 сая төгрөгөөр үнэлж 2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хүлээн авсан байна.

Зураг 3

НХМ№ггг Т-3

Саясийн салбарын 2017 оны 317 дугаар тогтоомжийн заавартай

ТООЦООНЫ ҮЛДЭГДИЙН БАТАЛГАА №

Нэхэмжлэгч: Байгууллагын нэр: "Баянтээг ХК" Харуулагч: Байгууллагын нэр: "Өвбаян-Улаан" ХХК

Хаяг: Өв, Нарийнтээл сум Хаяг: Өв, Баруунбаян-Хуяг сум

Утас, факс: Утас, факс: Э-шуудан: Э-шуудан: Банкны нэр: Банкны нэр: Банкны диваны дугаар: Банкны диваны дугаар:

ТООЦОО НИЙЛСЭН ДАНСНЫ №

Нэхэмжлэгчийн өмнөөс: Нярав ажигтай овогтой нь тооцогчийн өмнөөс Нярав ажигтай овогтой 3 овогтой Ариун -тай тус хоёр байгууллага хооронд 2020 оны 10 сарын 10 өдөрөөс 2020 оны 10 сарын 27 өдрийг зуустал хугацаанд өгч авчирсан үндэстэй хоёр байгууллага хооронд буй нэгдсэн болов бүртгэлийн хэргээр үйлдсэн ба хураангуй бүртгэлийн биеллээр нэг бүртгэл шийж үзэхэд 51,2 сая.000.000 (төгрөг) хэмээх (Төгрөг) хэмээх Нярав мал 21 нарт үйлдсэн хэргийн оргой гарсныг харилцан батлав.

Энэхүү оргой үлдэгдлийг тооцооны хэлбэрээр нэхэмжлэн авахаар

Тохиромж: Нэхэмжлэгч байгууллагын нягтлан бодогч: Н. Данзан Харуулагч байгууллагын нягтлан бодогч: З. Пунцаг

Хавсралт ----

Тооцоо нийлсэн акт

1. Тус 2 байгууллагын хооронд 2020 оны 10 дугаар сарын 10-ний өдөр өгч авчирсан барааг нэгбүртлэн нүд тоолон тоолж үзэхэд дараах байдлаар тоологдлоо.

2. Үүнд:

№	Малын төрөл	Тоо ширхэг	Бэлэн тоологдсон мал	Хүлээн авсан мал
1.	Адуу	9	9	9
2.	Үхэр	20	20	20
3.	Хонь	144	144	144
4.	Хурга	10	10	10
5.	Эр ямаа	52	52	52
6.	Эм ямаа	56	56	56
7.	Малын хашаа	1	1	1
8.	Нийт мал	291	291	291

3. Мал тоолж хүлээн авсан, хүлээлгэн өгсөн:

"Баянтээг" ХК-ийн нягтлан бодогч: Н. Данзан "Өвбаян-Улаан" ХХК-ийн нярав: З. Пунцаг Малчин: С.Хадбаатар

2020-10-14

Баянтээг ХК-аас нярав, захирлын жолооч, малчин 2 хүн нийт 4 хүний бүрэлдэхүүнтэй малыг тоолж хүлээн авсан байна. Үүнээс гадна малыг хүлээлгэн өгөхөд 2 талаас удирдах шатны албан тушаалтан оролцоогүй, ТУЗ-ийн шийдвэргүйгээр 51.2 сая төгрөгийн авлагыг биет хөрөнгөөр барагдуулахаар шийдвэрлэжээ. Аудитын явцад дээрх зөрчлийг Баянтээг ХК-с ажлын хэсэг байгуулагдан буцаан хүлээлгэн өгчээ.

Зураг 4

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
"БАЯНТЭЭГ" ХУВЬЦААТ КОМПАНИ
 62261 Баянтээг, Нарийнтээл сум, Өвөрхангай аймаг,
 И-мэйл: bntg_mining@yahoo.com
 2020.10.02 № 90
 тантай _____-ны № _____-т
ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тус компанид Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газар 11 дүгээр сард гүйцэтгэлийн аудит орсон. Аудитаар "Өв Баян-Улаан" ХХК-иас нүүрсний өрөнд 51,2 сая төгрөгийн өртөгтэй 291 толгой мал хүлээн авсныг ТУЗ-ийн шийдвэргүй тул буцаан өгөх, өрийн гэрээний дагуу мөнгөн хэлбэрээр барагдуулах зөвлөмж өгсний дагуу манай байгууллагаас ажлын хэсэг гаран малыг хүлээлгэн өгсөн болно.

ЗАХИРАЛ Н. Данзан

МАЛ БУЦААН ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

2020.11.30

ХҮЛЭЭЛГЭН ӨГЧ БҮЙ БАЙГУУЛАГА: "Баянтээг" ХХК
ХҮЛЭЭН АВЧ БҮЙ БАЙГУУЛАГА: "Өвбаян-Улаан" ХХК

Тус "Өвбаян-Улаан" ХХК компани нь нүүрсний өр төлбөрөөс 51170000 /тавин нэгэн сая нэг зуун далан мянган /төгрөгийн өрөнд 2020 оны 10 дугаар сарын 14-ны өдөр манай компаний малчин С.Хадбаатар, нягтлан бодогч З.Пунцаг, жолооч Т.Баасансүрэн нар, "Баянтээг" ХХК компаний 4 ажилтан-Мандсайхан, Ган-Отгон, Алтан-Очир, Бумбаяр нарыг байлцуулан акт үйлдэн нийт 291 толгой мал, 1 малын хашааг Тарагт сумын нутаг Үйзэн гэдэг газар хүлээлцсэн.

Аймгийн Аудитын газраас очсон хяналт шалгалтаар байгууллагын өр төлбөрийг мөнгөн хэлбэрээр төлнө гэсэн гэрээний заалтыг зөрчсөн зөрчил илэрсэн.

Дээрх зөрчлийг "Өвбаян-Улаан" ХХК-д танилцуулснаар малыг буцаан олгож, төлбөрийг мөнгөн хэлбэрээр авахаар боллоо. Үүний дагуу "Өвбаян-Улаан" ХХК-д дараах мал, малын хашаа саравчийг хүлээлгэн өглөө.

Акт үйлдсэн огноо: 2020 оны 11 сарын 30-ний өдөр

№	Малын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Үлдэгдэл	Тайлбар
1.	Адуу	9	750,000	9	Бүрэн
2.	Үхэр	20	800,000	20	Бүрэн
3.	Хонь	144	100,000	144	Бүрэн
4.	Хурга	10	30,000	10	Бүрэн
5.	Эр ямаа	52	60,000	52	Бүрэн
6.	Эм ямаа	56	100,000	56	Бүрэн
7.	Малын хашаа	1	5000,000	1	Бүрэн

Хүлээлгэн өгсөн:
 "Баянтээг" ХК-ийн захирал Н. Данзан
 Е/санхүүч Ю. Ариунтунгалаг
 Нярав Ган-Отгон
 Малчин _____

Хүлээн авсан:
 "Өвбаян-Улаан" ХХК-ийн захирал Г.Билгүүн
 Нягтлан бодогч З.Пунцаг
 Малчин С.Хадбаатар

Нарийнтээл сум, Баянтээг баг
 Утас: 88295162

Баруунбаян-Улаан сум, Хөвөөр
 Утас: 98030007, 93023414

Б.3 Удирдлагын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй, зарим зардлуудад хяналт хангалтгүй байна.

Б.3.1 Удирдлагын үйл ажиллагааны зардлын төлөвлөлт үндэслэлгүй, зарим зарцуулалтын хяналт хангалтгүй байна.

Санхүүгийн тайлангаас харахад 2019 онд 5,553.1 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажиллаж, 3,146.2 сая төгрөгийн зардал гарч, орлогын албан татварт 240.7 сая төгрөгийг төлж, 2,166.2 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Баянтээг ХК-н Санхүүгийн тайлангаар 2018 онд 2,018.5 сая төгрөг, 2019 онд онд 2,166.2 сая төгрөгийн ашигтай ажилласан. ТУЗ-ийн шийдвэрээр ногдол ашгийг дараах байдалтай хуваарилсан байна.

Хүснэгт 12

Д/д		2018 он	2019 он	
1	Ашиг	2,018.5	2,166.2	
2	Ногдол ашиг хуваарилалт	1,000.0	800.0	
3	Үүнээс	Нийт ногдол ашгийн 10 хувийг татварт	100.0	80.0
4		Орон нутагт	630.0	504.0
5		Шунхлай групп	216.0	172.8
6		Иргэд	54.0	43.2

Орон нутгийн төсөвт компанийн ногдол ашгаас 2019 онд 630.0 сая төгрөгийг хуваарилсан боловч орон нутгийн төсөвт оруулахгүй Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.7.1 дэх хэсэг “орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг”-т заасныг зөрчин дараах ажлуудыг хийсэн байна. Үүнд:

- Арвайхээр сумын халаалтын зуухнуудад шүүлтүүр тавих ажилд 400.0 сая төгрөгийг “Хангамж-Өргөө” ХХК-д шилжүүлсэн.
- “Өв Эко Мийт” ХХК-тай байгуулсан 450.0 сая төгрөгийн зээлийн гэрээний хэрэгжилтийг дуусгавар болгох ТУЗ-ийн шийдвэрийн дагуу орон нутагт ногдох ногдол ашгаас үе шаттайгаар тооцож барагдуулах ажлын хүрээнд 230.0 сая төгрөгийг суутган авчээ.

ТУЗ-ийн 2020 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 13 тоот тогтоолоор 2019 оны нийт ашгаас хуваарилсан ногдол ашиг болох 504.0 сая төгрөгийг олгохоор тогтоосон. Мөн “Өв Эко Мийт” ХХК-д зээлүүлсэн 450.0 сая төгрөгийн үлдэгдэл 220.0 сая төгрөгийг ТУЗ-ийн шийдвэрийн дагуу орон нутагт ногдох ногдол ашгаас суутган авч, үлдэгдэл 284.0 сая төгрөгийг 2020 оны 12 дугаар сард шилжүүлэхээр төлөвлөсөн байна.

ТУЗ-ийн 2019 оны 2 дүгээр сарын 11-ний өдрийн 2 тоот тогтоолоор 4186.4 сая төгрөгийн зардал төлөвлөж, ажилчдын цалинг 29 хувиар нэмэгдүүлсэн, техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлд 2,735.5 сая төгрөг, шахмал түлшний үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмжид 1,000.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Дээрх зардлуудыг зарцуулсан хэдий ч 2019 онд борлуулалтын орлого 42 хувиар давж, нийт зарлагыг 5.5 хувиар хэмнэсэн байна.

Нийт зардлын 21%-ийг үндсэн болон нэмэгдэл цалин, 18%-ийн түлш, шатах тослох материал, 10.9%-ийг хөрөнгийн элэгдэл, 19.6%-ийг татвар төлбөр хураамж, 4%-ийг нийгмийн өмнө хүлээх хариуцлага, 5%-ийг техникийн их засварын зардал эзэлж байна. Үлдэх 21.5%-ийг НДШ, Арга хэмжээний зардал, Гэрэл цахилгаан, хөдөлмөр хамгаалал, шагнал урамшуулах гэх мэт зардлууд эзэлж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийдвэрээр 2019 онд нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд 7 төрлийн ажлыг 385.0 сая төгрөгөөр хийхээр төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 3 төрлийн ажлыг 162.0 сая төгрөгөөр зохион байгуулж ажилласан байна. Тухайлбал:

- ✓ Нарийнтээл суманд халуун ус шинээр барих ажлыг 80.0 сая төгрөгөөр төлөвлөн нээлттэй тендер шалгаруулж Дүүрэн цацрах ХХК гүйцэтгэсэн
- ✓ Аймаг, сум орон нутгийн нэрийг алдаршуулж буй спортын тамирчдад дэмжлэг үзүүлэх ажилд 20.0 сая төгрөгийг төлөвлөн 22.9 сая төгрөгийг дэмжлэг хэлбэрээр олгосон. /Зардлын задаргааг хавсралт 1-д үзүүлэв/
- ✓ Нарийнтээл суманд Хөдөлмөрийн баатар, Далай даян Дархан аварга Д.Цэрэнтогтох аваргын хөшөө босгох ажилд 60.0 сая төгрөгийг төлөвлөн тендерт барималчин Оргил шалгарч гүйцэтгэсэн байна.

Компани нь 2020 онд нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд хэрэгжүүлэх ажилд 335.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөжээ. Тухайн оны 11 сарын байдлаар 288.5 сая төгрөгийг зарцуулсан байна. Дэлгэрэнгүйг дараах хүснэгтээс харах:

№	Ажлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Баянтээг багийн ЕБС-ийн дэмжлэг үзүүлэх	30.0	30.0
2	Баянтээг багийн цэцэрлэгийн дэмжлэг үзүүлэх	10.0	10.0
3	Баянтээг багийн хүн эмнэлэгт дэмжлэг үзүүлэх	10.0	10.0
4	Баянтээг багийн Хан уул орчимд мал угаалгын ванн барих	15.0	-
5	Аймаг, сум орон нутгийн нэрийг алдаршуулж байгаа спортын тамирчдад дэмжлэг үзүүлэх	20.0	3.5
6	Баянтээг багийн төвийн гэрэлтүүлгийн их засвар	10.0	10.0
7	Нарийнтээл сумын ЗДТГ-ын засвар	30.0	30.0
8	Баянтээг багийн ахмадын хороог дэмжих сан	5.0	3.0
9	Гүний худгийн цэвэршүүлэх төхөөрөмжний өргөтгөл	10.0	-
10	Нарийнтээл сумын Цэцэрлэгийн урлаг заалны өргөтгөл	45.0	45.0
11	Баянтээг багийн ЕБС-ийн барилгын их засвар	150.0	147.0
Нийт		335.0	288.5

Хүснэгт 13 /сая.төг/

Баянтээг ХК-ийн дүрмийн 7.3.13¹-т “Санхүүгийн жил дууссаны дараа, тухайн жилийн ашигт ажиллагааны түвшинг харгалзан компанийн цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр орон нутаг (аймаг, сум)-т нийгмийн хариуцлагыг хэрэгжүүлэх чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, уг хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ, зарцуулалтад нь нийт энгийн хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн саналыг тэдгээрийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тусгаж хэрэгжүүлэх талаар шийдвэр гаргах” гэсэн заалтыг зөрчиж нийгмийн өмнөх хариуцлагын хүрээнд нь 2019 онд 245.0 сая төгрөг, 2020 онд 75.0 сая төгрөгийг үндэслэлгүй төлөвлөж мөн дэмжлэг нэрээр 76.4 сая төгрөгийн хандив олгосон зөрчил илэрсэн.

Компанийн зүгээс 2019, 2020 онуудад нийгмийн хариуцлагын хүрээнд хийгдсэн нийт 6 төрлийн хөрөнгө оруулалтын ажлуудыг Нарийнтээл сум эсвэл Баянтээг багт хэрэгжүүлж иржээ. Компанийн дүрэмд заасны дагуу аймаг болон сумд хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулахаар заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

Сэлбэг, техникийн урсгал засвар болон техникийн их засварын зардлаас 74.7 сая төгрөгийг хэмнэгджээ. Тэсэлгээний материалд 30.0 сая төгрөгийг төлөвлөөд зарцуулаагүй байгаа нь тус компани нь тэсэлгээ хийх тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан учир зарцуулагдаагүй хэмнэгдсэн байна.

Тухайн жилд дараах зардлуудыг хэтрүүлэн зарцуулжээ. /сая.төг/

Хүснэгт 14

Д/д	Зардлын ангилал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт	Шалтгаан
1	Бичиг хэрэг	3.3	3.6	-0.3	
2	Шатах тослох материал	676.8	719.0	-42.1	4 төрлийн авто техник авсан. Хөрс хуулалтын төлөвлөгөөг давуулсан.
3	Хэвлэл захилга	2.0	2.7	-0.7	
4	Тэтгэмж тусламж	75.0	78.7	-3.7	Тэтгэвэрт гарсан
5	Элэгдлийн зардал	313.2	433.3	-120.1	Шинээр 4 хүнд даацын техник авсан.
6	Татвар төлбөр хураамж	686.4	777.3	-90.9	Нүүрсний борлуулалтын төлөвлөгөөнөөс давсан 60,633 тн нүүрсний нэмэгдсэн өртгийн албан татварт
7	Түлшний хөнгөлөлт	8.7	12.2	-3.5	
8	Ажилчдын хоолны зардал	20.9	39.2	-18.4	
9	Дотоод нүүрс	15.8	18.8	-2.9	
10	Арга хэмжээний зардал	28.5	39.7	-11.2	
11	Бусад	20.0	25.6	-5.6	
	Дүн	1850.6	2149.9	-299.4	

Бэлэн мөнгөний зарцуулалт буюу кассын тайлангаар оны эхэнд 79.3 сая төгрөгийн үлэгдэлтэй гарч, 291.4 сая төгрөгийн орлогыг оруулсан байна. Үүнд:

- ✓ Харилцахаас 267.0 сая төгрөг
- ✓ Цалингийн урьдчилгааг буцаан төлсөн нь 3.8 сая төгрөг
- ✓ Нүүрсний борлуулалтын орлогыг бэлнээр 20.6 сая төгрөгийг оруулжээ.

Зарцуулалт нь: Харилцах дансанд 51.6 сая төгрөгийг төвлөрүүлж, 288.9 сая төгрөгийг зарцуулан оны эцэст 30.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. /Зардлын задаргааг хавсралт 2-с харах/

Компанийн ТУЗ нь бэлэн мөнгөний зарцуулалтад дээд хязгаар, лимент тогтоож өгдөггүй. Кассын үлдэгдэл сар бүрийн эцэст өндөр дүнтэй байхад харилцах данснаас их хэмжээгээр мөнгөн хөрөнгийг кассад татан авсан нь мөнгөн хөрөнгийг хяналтгүй, үр ашиггүй зүйлд зарцуулах, санхүүгийн эмх замбараагүй байдлыг бий болгох эрсдэлийг үүсгэж байна.

Б.3.2 Түлш шатахууны зардлыг арвиан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

Баянтээг ХК-ийн 2019 онд Шатахууны зардалд 649.4 сая төгрөг, Тос, тосолгооны материалд 26.7 сая төгрөгийг төлөвлөжээ. Гүйцэтгэлээр 26.7 сая төгрөгийн тос, тосолгооны материал, 709.6 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Үүнд:

- Бензин 6847 л буюу 12.7 сая төгрөг
- Дизель түлш 304273 л буюу 665.7 сая төгрөг
- НИК-ийн талоноор 31.1 сая төгрөгөөр зарцуулжээ.

Төлөвлөснөөс 42.1 сая төгрөгийн хэтрэлттэй зарцуулсан байна. Авто техникт зарцуулсан 736.3 сая төгрөгийн шатах, тослох материал болон түлш, шатахууны задаргааг хүснэгтээр харуулбал:

/сая.төг/
Хүснэгт 15

		Тоо ширхэг	Зарцуулсан ШТМ, түлш, шатахуун
1	Хүнд даацын авто машин	10	256.6
2	Хүнд даацын мехнизм	7	385.6
3	Суудлын машин	4	39.4
4	Мотоцикл	3	0.6
5	Автогридор	1	5.9
6	Станц	1	3.0
7	Компрессор	1	0.7
8	ЭКГ-5А	1	2.6
9	Ачааны машин	5	19.3
10	Авто кран	1	1.0
11	ТУЗ-ийн гишүүдэд		1.7
12	ААН, Албан байгуулагд		1.0
13	Иргэнд		13.5
14	Шахмал түлшний үйлдвэрт		0.9
15	Бусад		4.5
	Нийт дүн		736.3

Тус компанийн тээврийн хэрэгслүүдэд зарцуулах шатах тослох материалд норм норматив баримтлаагүй, жолоочийн тооцоог боддоггүй, түлш шатахууны хяналтгүй зарцуулжээ. Хүнд даацын машин механизм нь мото цагаар ажилладаг боловч албан ёсны норм норматив байхгүй, тооцоо бодсон актгүй, хуваарьт ажлын дагуу өдөр болгон ажилладаг хариуцлагатай жижүүрийн бүртгэлийн мэдээлэл дутуу бүртгэгдсэн, анхан шатны бүртгэл хангалтгүй байна.

Б.3.3 Сэлбэг хэрэгслийн зардлыг арвиан хэмнэлттэй зарцуулсан ч, тайлагналт хангалтгүй байна.

Тус компани нь 2019 онд сэлбэгийн зардалд 141.0 сая төгрөг, техникийн урсгал засварт 50.0 сая төгрөг, техникийн их засварт 213.2 сая төгрөгийг тус тус төсөвлөж, гүйцэтгэлээр сэлбэгийн зардалд 82.4 сая төгрөг, техникийн урсгал засварт 48.5 сая төгрөг, техникийн их засварт 198.6 сая төгрөгийг зарцуулж, 74.7 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Аудитын явцад сэлбэгийн тайлангаар 167.6 сая төгрөгийн эхний үлдэгдэлтэй 151.5 сая төгрөгийн сэлбэгийг орлогод авч 194.2 сая төгрөгийн сэлбэгийг шаардах хуудсаар гарган зарцуулж, 124.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй гаргасан байна.

Компанийн сэлбэг хэрэгслийн үлдэгдлийг жагсаалтаар авч үзэхэд: тухайн сэлбэг хэрэгсэлд тохирох техник нь актлагдаж данснаас хасагдсан, үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө, олон жилийн хугацаанд ашиглагдаагүй сэлбэгийн үлдэгдэл их байна.

Авто инженер нь сэлбэг хэрэгсэл, засварын ажлын зарцуулалтын тайланг нийт техник хэрэгслийн ажилласан мото цагаар тооцоолж, анхан шатны баримтаар техник тус бүрээр хөтлөн бүртгэж хэвшсэн байна.

Засвар, сэлбэгийн төлөвлөгөөнд тусгагдаагүй 60.9 сая төгрөгийн засварыг Hyundai 520LC-9S маркийн экскаваторт хийж гүйцэтгэсэн байна. Ашиглалтын явцад тооцоолоогүй эвдрэл, гэмтэл гарч техник хэрэгсэлд засвар үйлчилгээг шуурхай хийх шаардлага үүсдэг байна.

Сэлбэгийн зардлыг техникийн ашиглалтаар ангилан харуулбал: /сая.төг/
Хүснэгт 16

Д/д	Техник хэрэгсэл	Тоо ширхэг	Сэлбэгийн нийт зарцуулалт
1	Хүнд даацын автомашин	9	86.5
2	Хүнд даацын механизм	6	87.4
3	Суудлын автомашин	4	14.4
4	Ачааны автомашин	4	5.9
5	Авто кран	1	1.9
6	ЭКГ-5А	1	39.7
Нийт дүн		25	235.8

Б.3.4 Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөв тооцсон боловч хөрөнгийн дахин үнэлгээг хийгээгүй байна.

Баянтээг ХК нь 2019 оны эхэнд 6,718.0 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан ба тайлант онд 4,308.3 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч, оны эцэст 11,026.3 сая төгрөгийн үндсэн хөрөнгөтэй болжээ. Хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэл 5,140.4 сая төгрөг байсан бол тайлант онд байгуулсан элэгдэл 433.3 сая төгрөг, нийт хуримтлагдсан элэгдэл 5,573.6 сая төгрөг болсон байна. Тайлант онд шахмал түлшний үйлдвэрийн 1,425.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийн угсралт, барилгын ажил дуусаагүй байсан тул элэгдэл байгуулаагүй байна. Үндсэн хөрөнгийн элэгдлийг хөрөнгийн ангиллаар нь авч үзвэл:

- Барилга байгууламж 58.1 сая төгрөг
- Машин, тоног төхөөрөмж 185.5 сая төгрөг
- Тээврийн хэрэгсэл 168.1 сая төгрөг
- Тавилга эд хогшил 21.6 сая төгрөгийн элэгдэл тус тус байгуулсан байна.

Үндсэн хөрөнгийн элэгдэл нь 2018 оноос 120.1 сая төгрөгөөр нэмэгдсэн нь барилга байгууламж дээр дээврийн засвар, 4 айлын 2 орон сууцны их засвар, төвийн шугамд холбосон болон 4ш авто техник худалдан авсантай холбоотой байна.

Баянтээг ХК нь 2018 оны дахин үнэлгээ хийх журмын дагуу хөрөнгийн дахин үнэлгээг хийгээгүй байгаа нь Хөрөнгийн үнэлгээний тухай хулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 4 дэх хэсэг болон МУ-ын Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалыг тус тус зөрчсөн байна.

В. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

В.1 Хөрөнгийн худалдан авалтыг хуулийн дагуу үр ашигтай хэрэгжүүлэн ажилласан байна.

В.1.1 Эд хөрөнгийн худалдан авалт үр дүнтэй болсон байна.

Баянтээг ХК-ийн 2019 оны хөрөнгө оруулалтыг 3,170.0 сая төгрөгөөр төлөвлөсөн байна. Үүнээс:

- ✓ 12 айлын орон сууцыг төвийн халаалтад холбох зардалд 50.0 сая төгрөг

- ✓ Халуун ус засварлах зардалд 20.0 сая төгрөг
- ✓ Конторын засварын зардалд 50.0 сая төгрөг
- ✓ Өвлийн хүлэмж барих зардалд 15.0 сая төгрөг
- ✓ Шахмал түлшний үйлдвэр барих зардалд 1,000.0 сая төгрөг
- ✓ Техник хэрэгсэлд 2,035.0 сая төгрөгийг дараах жагсаалтаар баталсан байна. /сая.төг/
Хүснэгт 12

№	Зардлын төрөл	Тоо, хэмжээ	Улс	Дүн
1	Экскаватор /цахилгаан, гидро хосолсон, 4м ³	1	Орос	800.0
2	Авто чиргүүл	3	Хятад	110.0
3	Хайгуулын өрмийн машин	1	Хятад	200.0
4	Пүүний засвар	1	Монгол	15.0
5	Автогрейдер	1	Хятад	250.0
6	Норд өөрөө буулгагч	2	Хятад	660.0
	Нийт дүн			2,035.0

Хайгуулын өрмийн машин худалдан авах ажлыг 2019 оны 04 дүгээр сарын 09 тоот ТУЗ-ийн тогтоолоор үнийн дүнд багтаан хайгуулын өрөм тавих зардал болгон өөрчилжээ. Гүйцэтгэлээр 3,841.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийдсэн байна. Үүнд:

- ✓ 12 айлын орон сууцыг төвийн халаалтад холбох зардалд 50.0 сая төгрөг
- ✓ Халуун ус засварлах зардалд 20.0 сая төгрөг
- ✓ Конторын засварын зардалд 50.0 сая төгрөг
- ✓ Шахмал түлшний үйлдвэр барих зардалд 1,000.0 сая төгрөг
- ✓ Экскаватор 850 марктай 1,889.0 сая төгрөг
- ✓ Автогрейдер 285.0 сая төгрөг
- ✓ Норд өөрөө буулгагч 2 ширхэг 592.0 төгрөгөөр худалдан авсан байна.

Төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлууд хийгдээгүй байна. Үүнд:

- ✓ Өвлийн хүлэмж барих 15.0 сая төгрөг
- ✓ Авто чиргүүл 110.0 сая төгрөг
- ✓ Хайгуулын өрөм тавих 200.0 сая төгрөг
- ✓ Пүүний засвар 15.0 сая төгрөг байна.

В.1.2 Үндсэн хөрөнгийг худалдан авах ажиллагаа хуулийн дагуу явагдсан байна.

Баянтээг ХК нь 2019 оны 3 дугаар сарын 14 тоот албан бичгийг ОНӨГазарт хүргүүлж, өөрийн хөрөнгөөр худалдан авах хүнд даацын техник хэрэгслийн тендерийг зарлаж шалгаруулалтыг явуулж өгөхийг хүсжээ. Хүнд даацын техник хэрэгслийн нийт төсөвт өртөг нь 2,035.0 сая төгрөг. Шалгарч гэрээ байгуулсан төсөвт өртөг 2,733.5 сая төгрөг байна. Аудитын явцад тендерт оролцогчдын ирүүлсэн материалыг шалгахад гүйцэтгэгчээр шалгарсан аж ахуйн нэгж бүх шаардлагыг хангажээ. Доорх техник хэрэгслийн худалдан авах ажиллагааг хуулийн дагуу Орон нутгийн өмчийн газраар дамжуулан худалдан авсан байна. Үүнд:

- **Экскаватор нийлүүлэх тендер**

Экскаватор нийлүүлэх тендерийн баримт бичигт нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр олгохгүй бөгөөд барааг 100% нийлүүлж акт үйлдсэний дараа төлбөрийг бүрэн олгохоор заагдсан. Сүүлийн 2 жилд ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагатай байх бөгөөд борлуулалтын орлого нь санал болгосон үнийн дүнгийн 50%-аас багагүй байхаар заажээ. Бараа нийлүүлэх ажлын нийт төсөвт өртөг нь 2.0 тэрбум төгрөг байна.

Уг экскаватор нийлүүлэх тендерийг нээлттэй тендерийн аргыг ашиглан зохион байгуулсан бөгөөд 2 удаа зарлагджээ. Эхний тендерийг 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдөр зарлаж 2 компани / “Вагнер ази тоног төхөөрөмж ХХК, Говь экуйпмент рентал флийт ХХК”/ үнийн санал, тендерийн баримт бичгийг боловсруулан оролцсон. Оролцогч компаниудын хувьд татварын өртэй байсан учраас тендерийг дахин зарласан. Дараагийн тендерт Говь экуйпмент рентал флийт ХХК татварын өрийг бүрэн барагдуулан оролцож тендерийн гүйцэтгэгчээр шалгарчээ.

- **Авто грейдер, хүнд даацын өөрөө буулгагч авто самосвал нийлүүлэх тендер**

Авто грейдер, хүнд даацын өөрөө буулгагч авто самосвал нийлүүлэх тендерийг 2 багц болгон худалдан авах ажиллагааг зохион байгуулжээ. 1 дүгээр багц дахь өөрөө буулгагч авто самосвал нийлүүлэх тендерт 4 аж ахуй нэгж, 2 дугаар багц дахь авто грейдер нийлүүлэх ажилд 3 аж ахуйн нэгж үнийн санал ирүүлсэн бөгөөд сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулжээ. Өөрөө буулгагч авто самосвал нийлүүлэх ажилд Нутгийн буян групп, авто грейдер машин нийлүүлэх ажилд Нисээч интернэшнл ХХК тус тус шалгарсан байна.

Тендерийн гүйцэтгэгчээр шалгарсан 3 аж ахуйн нэгжийн хувьд техникийн тодорхойлолтын үзүүлэлтээс давсан техник хэрэгслийг нийлүүлсэн байна. Ашиглалтын баталгаат хугацааг тендерийн тодорхойлолтоос давуулан нийлүүлсэн нь ашиглалтын явцын сервис үйлчилгээг нийлүүлэгч компани бүрэн хариуцаж ажилласантай холбоотой байна.

В.2 Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр дүнтэй боловч эд хөрөнгийн тооллогын үр дүн хангалтгүй байна.

В.2.1 Эд хөрөнгийн тооллого, тооцоог хуулийн дагуу хийгдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.


Баянтээг ХК-ний гүйцэтгэх захирлын 2019-06-28, 2019-12-17 өдрийн “Үндсэн болон эргэлтийн хөрөнгө тоолох тооллогын комисс байгуулах тухай” А/15, А/34 тоот тушаалаар 5 хүний бүрэлдэхүүнтэй томилогдсон комисс нь 2019 оны үндсэн ба эргэлтийн хөрөнгийн тооллогыг зохион байгуулсан боловч тооллого тооцооны талаар хууль журмын дагуу үнэн зөв явуулсан тухай “илтгэх хуудас”-аар санхүүд ирүүлээгүй, хөрөнгийн илүүдэл, дутагдал гаргаагүй ажилласан талаар “үр дүн”-г тодорхойлон үнэлэлт дүгнэлт өгөөгүй, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 3 дугаар хэсгийн 1-д заасны дагуу өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, хурлын тэмдэглэл хөтлөөгүй зөрчил илэрсэн.

В.2.2 Машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн явагдаж байна.

Машин техник хэрэгслийг төлөвлөгөөт ажил эхлэхийн өмнө бүрэн шалгаж шаардлагатай засварын ажлыг гүйцэтгэж зориулалтын дагуу ажилд нь гаргадаг байна. Компанийн хувьд автомеханик хариуцсан инженертэй бөгөөд бүх техник хэрэгслийн ашиглалт, засвар үйлчилгээг хариуцан ажиллаж байна. Компани нь нийт 9 авто гаржтай бөгөөд хуваарийн дагуу хөрс хуулалтад ашиглагдсан машин техникийг авто гаржийн барилгад хадгалдаг байна. Аудитын явцад зарим хөрс хуулалтад ашиглагдсан техникийг гадна хашаанд хадгалж байлаа. 2019 онд шинээр худалдан авсан 2 ширхэг САМС НМ-390 авто самосвал нь компанийн авто гаражид багтах боломжгүй байгаа бөгөөд шинээр авто гаржийн барилга барих шаардлага үүссэн байна.

Үндэсний аудитын газрын харьяа
Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар

Холбогдох байгууллагын санал:



МОНГОЛ УЛС
ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГА
62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас: 7032 2325, Факс: 7032 2376

2020.12.11 № 1/501
танай 2020.12.08 -ны № 454 -Т

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Баянтээг ХК-ний 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд дараах саналыг хүргүүлж байна.

- 1.Хүнд даацын машин худалдан авахад яагаад өндөр дүнтэй үнийн зөрүү үүссэн тухай тодруулах,
- 2.Хөрс хуулалтын шугам, олборлолтын шугамын зөрүү яагаад гарч байгааг тодруулах,
- 3.Хөрс хуулалт ТЭЗҮ-тэй нийцэж буй эсэхийг тодруулах.



А.ИШДОРЖ

011500789
D:My Doc. A5 albanbichig /ZD/



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ**

62173 Өвөрхангай аймаг, Арвайхээр сум,
Утас/Факс: (976) 7032 2354

2020.12.11 № 1/182
танай 2020.12.08 ны № 452 -Т

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

“Баянтээг ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлантай танилцлаа.

Тайлантай холбоотой санал байхгүй болно.

ДАРГА

О.ПҮРЭВДОРЖ



100230262



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
“БАЯНТЭЭГ” ХУВЬЦААТ КОМПАНИ

62261 Баянтээг, Нарийнтээл сум, Өвөрхангай аймаг,
И-мэйл: bntg_mining@yahoo.com

2020.12.11 № 93

танай 2020.12.08-ны № 453 -Т

ГӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ

Тус компани нь 2019 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, саналгүй болохыг мэдэгдье.

ЗАХИРАЛ-Т



Н.ДАНЗАН

D:\Baynteeг\A-5 blank.doc

Саналд өгсөн тайлбар:

Ирүүлсэн санал, баримт материалд үндэслэн дараах тайлбарыг өгч байна.

Аймгийн Засаг даргаас ирүүлсэн албан бичигт:

1. Хүнд даацын машин худалдан авахад яагаад өндөр дүнтэй үнийн зөрүү үүссэн тухай тодруулах.

Экскаватор нийлүүлэх ажлын санхүүжилтийг 2019 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд бүрэн тусгалгүйгээр 800.0 сая төгрөгөөр төлөвлөсөн. 2020 онд гүйцэтгэлээрх үлдэгдэл 1,089.0 сая төгрөгийг төлөвлөсөн байна.

2. Хөрс хуулалтын шугам, олборлолтын шугамын зөрүү яагаад гарч байгааг тодруулах.

Хөрс хуулалт, нүүрс олборлолтын төлөвлөгөөг хайгуулын шугамаар нь харахад:

Он	Хайгуулын шугам	Давуулан биелүүлсэн хувь	Олборлолтын шугам	Давуулан биелүүлсэн хувь
2018	ХШ 51-54	36.5	ХШ 40-43	28.8
2019	ХШ 52-54 ХШ 43-38	50.1	ХШ 53	50.5
2020	ХШ 47-51 ХШ 40-36	37.7	ХШ 36-43 ХШ 53-50	Хүлээгдэж байгаа
Нийт		124.3		79.3

Хүснэгтээс харахад: 2018 оны ХШ 51-54 шугам, 2019 онд ХШ 52-54 шугамуудад хийсэн байгаа нь хөрс хуулалтыг дээрх шугамуудад давхардуулан хийсэн байна. Дээрх 3 онд хөрс хуулалтыг 553,2 мян м³ буюу 124.3 хувиар давуулж биелүүлсэн боловч нүүрс олборлолтыг хуулсан талбайгаас хийгээгүй байна. **Энэ нь хөрс хуулалтын үр дүнд бий болсон олборлох бэлэн нүүрсний нөөцтэй учраас тухайн онуудад хөрс хуулсан хайгуулын шугамд олборлолтыг хийхгүй байна.**

3. Хөрс хуулалт ТЭЗҮ-тэй нийцэж буй эсэхийг тодруулах.

2019 онд хийгдэх хөрс хуулалтыг хайгуулын шугамаар нь харьцуулбал:

Техник эдийн засгийн үндэслэл /ТЭЗҮ/	2019 оны уулын ажлын төлөвлөгөө	2019 оны гүйцэтгэл
ХШ 44-45	ХШ 34-35	ХШ 52-54
ХШ 45-46	ХШ 35-36	ХШ 43-38
ХШ 46-47	ХШ 36-37	
ХШ 47-48	ХШ 37-38	
ХШ 48-49	ХШ 53-54	
ХШ 51-52	ХШ 54-55	
ХШ 52-53		
ХШ 53-54		
ХШ 54-55		

ХШ 55-56

Хүснэгтээс харахад: ТЭЗҮ, Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хөрс хуулалтын хайгуулын шугамууд зөрүүтэй байна. 2019 онд хөрс хуулсан хайгуулын шугам нь ТЭЗҮ, Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдаагүй хайгуулын шугамд хийгдсэн. Доорх хүснэгтээс хөрс хуулалт, олборлолт, борлуулалтын зөрүүтэй байдлыг харна уу.

№	Уулын ажлын нэр	Хэмжих нэгж	Техник, эдийн засгийн үндэслэл	2019 оны уулын ажлын төлөвлөгөө	2019 оны уулын ажлын гүйцэтгэл	Нөөцийн хөдөлгөөн		
						1962 он	1/1/2019	1/1/2020
						Анх батлагдсан нөөц /мян.тн/	Үлдэгдэл нөөц /мян.тн/	Үлдэгдэл нөөц /мян.тн/
1	Хөрс хуулалт	мян/м ³	655.05	400.0	600.3			
2	Нүүрс олборлолт	мян/тн	297.75	140.0	238.54			
3	Нүүрсний хаягдал	мян/тн	9.52	7.56	27.94			
4	Нүүрсний бохирдол	мян/тн	4.88	0.77	0			
5	Нүүрс борлуулалт	мян/тн	293.11	133.21	210.60			
6	Борлуулалтын орлого	сая/төг	5799.0	3863.1	6108.4			

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

БҮЛЭГ 1. Удирдлагын үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжиж байна.

А.1 Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааг хуулийн дагуу оновчтой хэрэгжүүлсэн байна.

А.1.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь үйл ажиллагааг хуулийн дагуу явуулсан байна.

А.1.2 Төлөөлөн удирдах зөвлөлөөс хэрэгжүүлсэн үйл ажиллагаа үр дүнтэй хэрэгжсэн байна.

А.1.3 Гүйцэтгэх удирдлагын зүгээс хэрэгжүүлсэн үйл ажиллагаа оновчтой байна.

А.2 Аудитын хороог байгуулан ажиллаагүй байна.

А.2.1 Аудитын хороо нь хууль, компанийн дүрэмд заасан эрх үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

А.2.2 Аудитын хороо байгуулагдаагүйгээс үүргээ гүйцэтгээгүй байна.

Б. Уулын ажлын төлөвлөлт үндэслэлгүй, авлага барагдуулах ажил хийгдээгүй, удирдлагын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй байна.

Б.1 Уулын ажлын төлөвлөлт үндэслэлгүй, биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй, харин дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийсэн байна.

Б.1.1 ТЭЗҮ-д нийцүүлэн уулын ажлын төлөвлөгөөг төлөвлөөгүй, зүсэлтийн дундаж талбайн тооцоолол алдаатай байна.

Б.1.2 Биологийн болон техникийн нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй, харин дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлтийг хийсэн байна.

Б.2 Уурхайн нүүрсний олборлолт, борлуулалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ч авлага барагдуулах талаар хангалтгүй байна.

Б.2.1 Нүүрсний олборлолт төлөвлөсөн хэмжээндээ хэрэгжиж байна.

Б.2.2 Нүүрсний борлуулалтын төлөвлөгөөг 50.4 хувиар давуулан биелүүлсэн нь төлөвлөлт үндэслэлгүй байна.

Б.2.3 Борлуулалтын орлогын төлөвлөгөөг 35.5 хувиар давуулсан боловч борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлээгүй байна.

Б.2.4 Авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй байна.

Б.3 Удирдлагын зардлыг үндэслэлтэй төлөвлөөгүй, зарим зардлуудад хяналт хангалтгүй байна.

Б.3.1 Удирдлагын үйл ажиллагааны зардлын төлөвлөлт үндэслэлгүй, зарим зарцуулалтын хяналт хангалтгүй байна.

Б.3.2 Түлш шатахууны зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулаагүй байна.

Б.3.3 Сэлбэг хэрэгслийн зардлыг арвилан хэмнэлттэй зарцуулсан ч, тайлагналт хангалтгүй байна.

Б.3.4 Үндсэн хөрөнгийн элэгдлийг зөв тооцсон боловч хөрөнгийн дахин үнэлгээг хийгээгүй байна.

В. Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтыг үр дүнтэй хэрэгжүүлж байна.

В.1 Хөрөнгийн худалдан авалтыг хуулийн дагуу үр ашигтай хэрэгжүүлэн ажилласан байна.

В.1.1 Эд хөрөнгийн худалдан авалт үр дүнтэй болсон байна.

В.1.2 Үндсэн хөрөнгийг худалдан авах ажиллагаа хуулийн дагуу явагдсан байна.

В.2 Өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт үр дүнтэй боловч эд хөрөнгийн тооллогын үр дүн хангалтгүй байна.

В.2.1 Эд хөрөнгийн тооллого, тооцоог хуулийн дагуу хийгдсэн ч хэрэгжилт хангалтгүй байна.

В.2.2 Машин техник, тоног төхөөрөмжийн ашиглалт, хадгалалт, хамгаалалт хэвийн явагдаж байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

Баянтээг ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Нэмэхбаяр болон гишүүд нарт

- Кассаар гарч байгаа бэлэн мөнгөний зарцуулалтын дээд хязгаарыг тогтоож өгөх.

Баянтээг ХК-ийн гүйцэтгэх захирал Н.Данзан, Ерөнхий инженер Л.Энх-отгон нарт:

- ТЭЗҮ-д нийцүүлэн уулын ажлын төлөвлөгөөг боловсруулж байх.
- Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсан хайгуулын шугамд хөрс хуулалт, олборлолтыг явуулж байх.

Баянтээг ХК-ийн гүйцэтгэх захирал Н.Данзан, Ерөнхий нягтлан бодогч Ю.Ариунтунгалаг нарт

- Харилцагч байгууллага, иргэд
- тэй үүссэн авлага, өглөгийг улирал тутам тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байх.
- Харилцагч байгууллага, иргэдтэй гэрээг байгуулахдаа авлага, өглөгийн үлдэгдлийн тооцоог нийлж баталгаажуулсны дараа гэрээг хийх.
- Төсвийн тухай хуулийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” заалтыг мөрдөж ажиллах.
- Гэрээний үүргийн биелэлтээ хангаагүй, гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн хэрэглэгчдэд хариуцлага тооцож ажиллах. /Нүүрс нийлүүлэх гэрээний 5 дугаар заалт Хариуцлагад 5.3-т “Хэрэглэгч байгууллагын хүсэлтийг харгалзан зээлээр олгосон нүүрсний үнийг тогтоосон хугацаанд төлөөгүй нөхцөлд хоногийн 0.5%-ийн алданги тооцно” гэсэн заалтыг мөрдөж ажиллах/.
- Бэлэн мөнгөний үлдэгдлийг их хэмжээгээр үлдээхгүй байх.
- Автомашин, хүнд даацын машин техник хэрэгслийн шатахууны зарцуулалт хяналт тавьж ажиллах.
- Сэлбэг хэрэгслийн дансанд бүртгэлтэй байгаа сэлбэг хэрэгслээс цаашид ашиглагдах боломжгүй сэлбэгийг өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн зохих журмын дагуу шийдвэрлэх.
- Сангийн сайдын 2018 оны 207 тоот тушаалын дагуу үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээг хийлгэх
- НББ-ийн тухай хуулийг мөрдөж ажиллах



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ**

2020 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/21

Арвайхээр

**Гүйцэтгэлийн аудитын тайланг
баталгаажуулах тухай**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 20 дугаар зүйлийн 20.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2018 оны А/207 дугаар тушаалаар батлагдсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүрэг”-ийн 5 дугаар хавсралтын 2.4 дэх заалт, мөн 2020 оны А/53 дугаар “Аудитын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Баянтээг” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудит тайлан /ӨВА-2020/04/-ГА/-г баталгаажуулсугай.
2. Аудитаар өгөгдсөн албан шаардлагын жагсаалтыг хавсралтаар баталсугай.
3. “Баянтээг” ХК-ийн 2019 оны үйл ажиллагааны үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга /О.Пүрэвдорж/, аймгийн Засаг дарга /А.Ишдорж/, “Баянтээг” ХК-ний ТУЗ-ийн дарга Д.Нэмэхбаяр, “Баянтээг” ХК-ний гүйцэтгэх захирал Н.Данзан тус тус хүргүүлсүгэй.
4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2021 оны 03 дугаар сарын 10-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг “Баянтээг” ХК-ний ТУЗ-ийн дарга Д.Нэмэхбаяр, “Баянтээг” ХК-ний гүйцэтгэх захирал Н.Данзан нарт зөвлөсүгэй.
5. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг аудитын менежер /Д.Гансүх/, аудитор /С.Шийлэгмаа/ нарт даалгасугай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТЖАРГАЛ

015010042

D:\Audiitiin gazar\Baiguullagiin dotood barimt\Tushaal

ХАВСРАЛТУУД:

Хавсралт 1.

